



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 02/02

Эрдэнэт

Орхон аймгийн Засаг даргын
2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга С.Батжаргалд ДААЛГАХ нь:

2.1. Хуралдаанд нийт төлөөлөгчдөөс гарсан саналуудыг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах;

2.2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд танилцуулах;

2.3. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.4 Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;



ДАРГА

Д.МӨНХБАТ

079130063